



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2025/177/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.selenge@audit.gov.mn">www.selenge@audit.gov.mn</a> Сүхбаатар сум 2025 он</p>	<p>Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 70363040 Цахим хаяг: <a href="mailto:enkhtuyach@audit.gov.mn">enkhtuyach@audit.gov.mn</a> Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 70363036 Цахим хаяг: <a href="mailto:batmunkhb@audit.gov.mn">batmunkhb@audit.gov.mn</a> Аудитын гүйцэтгэсэн: Мэдээлэл Аудит ХХК-ийн Сэлэнгэ салбар Утас: 99499667 Цахим хаяг: <a href="mailto:infoauditselenge@gmail.com">infoauditselenge@gmail.com</a></p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	5-9
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа .....	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	11
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12-14
4. Аудитын тайлан.....	15
4.1 Ерөнхий зүйл .....	15
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	17
5. Аудитын илрүүлэлт .....	17-19
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл .....	19-20

### Товчилсон үгийн жагсаалт

<b>УСНББОУС</b>	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
<b>АДБОУС</b>	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
<b>БШУЯ</b>	Боловсрол, шинжлэх ухааны яам
<b>БШУС</b>	Боловсрол, шинжлэх ухааны сайд
<b>БСШУС</b>	Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
<b>БШУГ</b>	Боловсрол, шинжлэх ухааны газар
<b>ЗГ</b>	Засгийн газар
<b>НДШ</b>	Нийгмийн даатгалын шимтгэл
<b>ХХОАТ</b>	Хувь хүний орлогын албан татвар
<b>ИТХ</b>	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
<b>ТБОНӨХБАУХАТ</b>	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай



## СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,  
Сэлэнгэ аймаг, 43081  
Утас/Факс: (976)-7036-3040  
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

ТҮШИГ СУМЫН ЕРӨНХИЙ  
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН  
ЗАХИРАЛ Б.БАЯРМАА ТАНАА

2025.02.25 № СЭА-2025/177/НА-СТА-ТШЗ  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд тус сургууль нь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр сургуулийн дээврийн засварын ажлыг 110,471.7 мянган төгрөгөөр “Хүчит Сэлэнгэ” ХХК гүйцэтгэснийг капиталжуулан бүртгэж, Персон хөтөлбөрийн хүрээнд 4 жилийн хугацаатай лизингийн гэрээгээр Мэксим консалтинг ХХК-иас нийлүүлсэн 84,997.0 мянган төгрөгийн цахим ангийн хэрэглэгдэхүүн, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, Боловсролын газраас 36,149.3 мянган төгрөгийн сурах бичиг, кабинетын хэрэглэгдэхүүн зэргийг үнэ төлбөргүй хүлээн авч орлогоор бүртгэсэн байна.

### Аудитын гол асуудал

Дээд шатны төсвийн захирагчаас тус сургуулийн тайлант оны төсвийн төлөвлөлт, хуваарилалтыг тухайн сарын гүйцэтгэлд үндэслэн тайлант онд нийт 9 удаа өөрчилж, зохицуулалт хийж байгаа буюу бодит гүйцэтгэлтэй уялдуулан

өөрчилж байгаа нь төсвийн төлөвлөлтийг тооцоо, судалгаанд үндэслэн бодитоор төлөвлөдөггүй болохыг харуулж байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Тус сургууль нь 2024 оны “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсан 26 зорилтын хүрээнд 32 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 98.0 хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

 Ч.ЭНХТУЯА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	202,606,744.43	222,905,182.38
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	116,021,041.54	146,047,534.99
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	116,021,041.54	146,047,534.99
3121	Төгрөг	116,021,041.54	146,047,534.99
31211	Төрийн сангийн харилцах	116,021,041.54	146,047,534.99
35	БАРАА МАТЕРИАЛ	86,585,702.89	76,857,647.39
353	Бэлэн бүтээгдэхүүн	782,910.00	3,555,280.00
354	Хангамжийн материал	85,802,792.89	73,302,367.39
3542	Аж ахуйн материал	40,061,755.00	24,322,715.00
3546	Хүнсний материал	1,513,800.00	1,136,020.00
3547	Бусад хангамжийн материал	44,227,237.89	47,843,632.39
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	1,916,394,097.69	2,097,479,110.99
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,916,394,097.69	2,097,479,110.99
392	Биет хөрөнгө	1,899,890,164.21	2,081,225,177.47
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,785,732,303.00	1,896,204,001.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(153,983,430.72)	(196,539,800.40)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	223,783,492.30	385,075,617.30
39206	Хуримтлагдсан элэгдэл	(100,118,404.25)	(138,904,532.41)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	66,567,939.25	66,567,939.25
39208	Хуримтлагдсан элэгдэл	(37,738,748.21)	(46,195,447.25)
39209	Зам, гүүрийн байгууламж	18,750,000.00	18,750,000.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	(16,800,000.28)	(17,450,000.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	19,149,500.00	19,149,500.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,131,141.60)	(4,957,369.92)
39216	Дуусаагүй барилга, байгууламж	83,356,389.00	83,356,389.00
39217	Ном	15,322,265.72	16,168,881.22
393	Биет бус хөрөнгө	16,503,933.48	16,253,933.52
39301	Програм хангамж	1,250,000.00	1,250,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(916,666.52)	(1,166,666.48)
39303	Бусад биет бус хөрөнгө	16,170,600.00	16,170,600.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	2,119,000,842.12	2,320,384,293.37
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,862,360.00	64,813,720.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,862,360.00	64,813,720.00
413	Өглөг	4,862,360.00	64,813,720.00
4131	Ажилчидтай холбогдсон өглөг		544,600.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,351,160.00	521,370.00
4136	Бусад өглөг	2,511,200.00	63,747,750.00
41361	Байгууллагад төлөх өглөг	2,511,200.00	63,747,750.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	2,114,138,482.12	2,255,570,573.37
51	Засгийн газрын хувь оролцоо	2,114,138,482.12	2,255,570,573.37
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	579,511,739.58	579,511,739.58
51101	Өмч: - төрийн	579,511,739.58	579,511,739.58
512	Хуримтлагдсан үр дүн	941,615,748.40	1,083,047,839.65
5121	Өмнөх үеийн үр дүн	941,615,748.40	941,615,748.40
5122	Тайлант үеийн үр дүн		141,432,091.25
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	593,010,994.14	593,010,994.14
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	2,119,000,842.12	2,320,384,293.37

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,368,199,637.14	1,876,683,227.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	58,281,481.14	167,399,133.00
120	Нийтлэг татварын бус орлого	58,281,481.14	167,399,133.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,781,598.00	3,376,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	140,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	44,635,530.90	160,406,438.50
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	5,864,352.24	3,616,394.50
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,309,918,156.00	1,709,284,094.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,892,500.00	1,507,165,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,892,500.00	1,507,165,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,025,656.00	202,118,794.05
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,025,656.00	202,118,794.05
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,262,308,706.13	1,735,251,135.80
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,262,308,706.13	1,735,251,135.80
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,225,831,706.13	1,696,381,635.80
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,490,098.63	1,136,955,576.01
210101	Үндсэн цалин	559,318,196.32	690,707,236.63
210102	Нэмэгдэл	208,815,959.70	405,131,755.63
210104	Урамшуулал	33,355,942.61	41,116,583.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,211,082.04	139,747,244.73
210201	Тэтгэврийн даатгал	67,162,217.72	96,410,535.35
210202	Тэтгэмжийн даатгал	7,906,019.28	11,400,231.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,373,181.14	5,756,858.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,505.82	5,235,923.99
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,158.08	20,943,695.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	148,841,256.00	170,170,794.05
210301	Гэрэл, цахилгаан	16,300,300.00	21,027,738.05
210302	Түлш, халаалт	131,791,456.00	145,732,656.00
210303	Цэвэр, бохир ус	749,500.00	3,410,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал		15,739,040.00
210408	Бараа материал акалсны зардал		15,739,040.00
2105	Нормативт зардал	45,072,960.00	46,387,890.00
210502	Хоол, хүнс	45,072,960.00	46,387,890.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	31,948,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	31,948,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,767,000.00	23,395,365.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,378,000.00	3,536,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,389,000.00	19,859,065.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	111,449,309.46	132,037,725.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,632,547.00	29,471,340.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,083,600.00	11,040,960.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	77,733,162.46	91,525,425.20
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	36,477,000.00	38,869,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	36,477,000.00	38,869,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	36,477,000.00	38,869,500.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	105,890,931.01	141,432,091.25
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	105,890,931.01	141,432,091.25

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,317,699,754.00	1,712,660,394.05
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,781,598.00	3,376,300.00
120	Нийтлэг татварын бус орлого	7,781,598.00	3,376,300.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,781,598.00	3,376,300.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	210,000.00	140,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,309,918,156.00	1,709,284,094.05
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,145,892,500.00	1,507,165,300.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,145,892,500.00	1,507,165,300.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	164,025,656.00	202,118,794.05
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	164,025,656.00	202,118,794.05
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,181,345,993.67	1,634,177,650.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,181,345,993.67	1,634,177,650.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,152,954,083.67	1,592,535,780.60
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	801,490,098.63	1,136,410,976.01
210101	Үндсэн цалин	559,318,196.32	690,162,636.63
210102	Нэмэгдэл	208,813,774.28	405,131,755.63
210104	Урамшуулал	33,358,128.03	41,116,583.75
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	98,211,082.04	139,747,244.73
210201	Тэтгэврийн даатгал	67,162,217.72	96,410,535.35
210202	Тэтгэмжийн даатгал	7,906,019.28	11,400,231.76
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,373,181.14	5,756,858.51
210204	Ажилгүйдлийн даатгал	1,524,505.82	5,235,923.99
210205	Эрүүл мэндийн даатгал	15,245,158.08	20,943,695.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	149,025,656.00	170,170,794.05
210301	Гэрэл, цахилгаан	16,300,300.00	21,027,738.05
210302	Түлш, халаалт	131,791,456.00	145,732,656.00
210303	Цэвэр, бохир ус	933,900.00	3,410,400.00
2105	Нормативт зардал	52,439,700.00	47,839,900.00
210502	Хоол, хүнс	52,439,700.00	47,839,900.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,000,000.00	31,948,000.00
210604	Урсгал засвар	15,000,000.00	31,948,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,767,000.00	23,020,365.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,378,000.00	3,536,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,389,000.00	19,484,065.81
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	31,020,547.00	43,398,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,936,947.00	32,675,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	9,083,600.00	10,722,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	28,391,910.00	41,641,870.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,391,910.00	41,641,870.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	28,391,910.00	41,641,870.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	136,353,760.33	78,482,743.45
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	31,957,500.00	48,456,250.00
	Дотоод эх үүсвэрээр	31,957,500.00	48,456,250.00
222001	Тоног төхөөрөмж	31,487,500.00	48,256,250.00
223001	Бусад хөрөнгө	470,000.00	200,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(31,957,500.00)	(48,456,250.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	104,396,260.33	30,026,493.45
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,021,041.54
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		146,047,534.99

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	941,615,748.40	2,114,138,482.12
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
5	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
7	Тайлант үеийн үр дүн			141,392,091.25	141,392,091.25
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	941,615,748.40	2,114,138,482.12
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
11	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
12	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
13	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				
14	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
15	Тайлант үеийн үр дүн			141,432,091.25	141,432,091.25
16	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	579,511,739.58	593,010,994.14	1,083,047,839.65	2,255,570,573.37

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэлийн зөрүү/хэтрэлт, хэмнэлт/	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,844,837,100.00	1,682,633,900.60	162,203,199.40	91.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,844,837,100.00	1,634,177,650.60	210,659,449.40	88.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,802,870,600.00	1,592,535,780.60	210,334,819.40	88.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,254,288,800.00	1,136,410,976.01	117,877,823.99	90.6
210101	Үндсэн цалин	785,113,200.00	690,162,636.63	94,950,563.37	87.9
210102	Нэмэгдэл	450,245,800.00	405,131,755.63	45,114,044.37	90.0
210104	Урамшуулал	18,929,800.00	41,116,583.75	(22,186,783.75)	217.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	156,786,200.00	139,747,244.73	17,038,955.27	89.1
210201	Тэтгэврийн даатгал	106,614,600.00	96,410,535.35	10,204,064.65	90.4
210202	Тэтгэмжийн даатгал	12,542,800.00	11,400,231.76	1,142,568.24	90.9
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,271,500.00	5,756,858.51	514,641.49	91.8
210204	Ажилгүйдлийн даатгал	6,271,500.00	5,235,923.99	1,035,576.01	83.5
210205	Эрүүл мэндийн даатгал	25,085,800.00	20,943,695.12	4,142,104.88	83.5
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	187,911,500.00	170,170,794.05	17,740,705.95	90.6
210301	Гэрэл, цахилгаан	26,205,700.00	21,027,738.05	5,177,961.95	80.2
210302	Түлш, халаалт	158,050,700.00	145,732,656.00	12,318,044.00	92.2
210303	Цэвэр, бохир ус	3,655,100.00	3,410,400.00	244,700.00	93.3
2105	Нормативт зардал	47,839,900.00	47,839,900.00		100.0
210502	Хоол, хүнс	47,839,900.00	47,839,900.00		100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	31,948,000.00	31,948,000.00		100.0
210604	Урсгал засвар	31,948,000.00	31,948,000.00		100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	29,331,000.00	23,020,365.81	6,310,634.19	78.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,536,300.00	3,536,300.00	-	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	25,794,700.00	19,484,065.81	6,310,634.19	75.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	94,765,200.00	43,398,500.00	51,366,700.00	45.8
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	84,042,600.00	32,675,900.00	51,366,700.00	38.9
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	10,722,600.00	10,722,600.00	-	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	41,966,500.00	41,641,870.00	324,630.00	99.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,966,500.00	41,641,870.00	324,630.00	99.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	41,966,500.00	41,641,870.00	324,630.00	99.2
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		48,456,250.00	(48,456,250.00)	
	Дотоод эх үүсвэрээр		48,456,250.00	(48,456,250.00)	
222001	Тоног төхөөрөмж		48,256,250.00	(48,256,250.00)	
223001	Бусад хөрөнгө		200,000.00	(200,000.00)	
1	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,844,837,100.00	1,682,633,900.60	162,203,199.40	91.2
131	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,507,165,300.00	1,477,138,806.55	30,026,493.45	98.0
131001	Улсын төсвөөс санхүүжих	1,507,165,300.00	1,477,138,806.55	30,026,493.45	98.0
132	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	219,859,500.00	202,118,794.05	17,740,705.95	91.9
132001	Орон нутгийн төсвөөс	219,859,500.00	202,118,794.05	17,740,705.95	91.9
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	117,812,300.00	3,376,300.00	114,436,000.00	2.9
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,376,300.00	3,376,300.00	-	100.0
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	114,436,000.00		114,436,000.00	-
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		116,021,041.54	(116,021,041.54)	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		146,047,534.99	(146,047,534.99)	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Түшиг сумын Ерөнхий боловсролын сургууль нь “Багш, сурагч, асран хамгаалагчийн хамтын оролцоонд суурилсан эх хэлээрээ уншиж ойлгох, илэрхийлэн тайлбарлах чадварыг хөгжүүлж, сурлагын чанарт ахиц гарган, бүх талын хөгжлийг хангана” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Сурагчдын ярих, бичих, илэрхийлэх, тайлбарлах чадварыг хөгжүүлэх,
- Багш нарын мэргэжлийн хөгжлийн бүлгийг сурагчдын нас сэтгэхүйн онцлогт тохируулан зохион байгуулж, удирдлага манлайллаар хамтран хөгжих нөхцөл боломжийг хангах,
- Сурагчдын бие даан хөгжих боломжийг ханган, сонгон дугуйлангийн чанар үр дүнд ахиц гаргаж, үзэсгэлэн, тайлант өдөрлөгийн хагас жил тутамд зохион байгуулж хэвших,
- Байгууллагын соёлыг хэвшүүлж хамт олон асран хамгаалагч, сурагчдын дунд харилцааны эерэг уур амьсгалыг бүрдүүлэх,
- Суралцагчдын эрүүл, аюулгүй орчинд суралцах таатай орчныг бүрдүүлэх.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- *Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 25-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор “Хувьсах зардал болон гүйцэтгэл, үр дүнд суурилсан санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 01 сарын 17-ны өдрийн 25 дугаар тогтоолоор” Боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны болон багшийн ажлын гүйцэтгэл, чанар, үнэлгээний үр дүнд үндэслэн олгох нэмэлт урамшууллыг санхүүжүүлэх журам”;*
- *Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ний өдрийн 128 дугаар тогтоолоор Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон;*  
*Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн 84 дүгээр тогтоолоор хөдөө орон нутгийн нэмэгдэл шинэчлэгдсэн гэх мэт.*

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд Боловсролын ерөнхий газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас хяналт, шалгалт

хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь Боловсрол, Шинжлэх Ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, Шинжлэх Ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/03 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 201,383.4 мянган төгрөгөөр буюу 9.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	116,021.0	146,047.5	30,026.5
Авлага	-	-	-
Бараа материал	86,585.7	76,857.6	(9,728.1)
Үндсэн хөрөнгө	1,916,394.1	2,097,479.1	181,085.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,119,000.8</b>	<b>2,320,384.2</b>	<b>201,383.4</b>
Өр төлбөр	4,862.4	64,813.7	59,951.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	2,114,138.4	2,255,570.5	141,432.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>2,119,000.8</b>	<b>2,320,384.2</b>	<b>201,383.4</b>

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 146,047.5 мянган төгрөг болж 30,026.5 мянган төгрөгөөр өссөн нь зардлын хэмнэлттэй холбоотой бөгөөд уг хэмнэлт төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсанаас,
- Бараа материалын дансны үлдэгдэл 76,857.6 мянган төгрөг болж 9,728.1 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 150,100.9 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн Боловсролын газраас 3,616.4 мянган төгрөгийн сурах бичгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч, сургуулийн захирлын 2024 оны 12 сарын 31-ний өдрийн А/30 дугаар тушаалаар 15,739.0 мянган төгрөгийн цаашид ашиглах боломжгүй хангамжийн бараа материалыг акталж, үйл ажиллагаанд 147,706.4 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,097,479.1 мянган төгрөг болж 181,085.0 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 27,207.0 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авч, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөр сургуулийн дээврийн засварын ажлыг 110,471.7 мянган төгрөгөөр “Хүчит Сэлэнгэ” ХХК гүйцэтгэснийг капиталжуулан бүртгэж, Персон хөтөлбөрийн хүрээнд 4 жилийн хугацаатай лизингийн гэрээгээр Мэксим консалтинг ХХК-иас нийлүүлсэн 84,997.0 мянган төгрөгийн цахим ангийн хэрэглэгдэхүүнийг, Дезерет олон улсын байгууллагаас 17,401.8 мянган төгрөгийн зөөврийн компьютер, аймгийн Боловсролын газраас 32,532.9 мянган төгрөгийн ном, кабинетын хэрэглэгдэхүүн үнэ төлбөргүй хүлээн авч, тайлант онд 91,525.4 мянган төгрөгийн элэгдлийн зардлаас тус тус шалтгаалсан байна.
- Өр төлбөр дансны үлдэгдэл 64,813.7 мянган төгрөг болж 59,951.3 мянган төгрөгөөр өссөн нь өмнөх өр төлбөрийг барагдуулж, Персон хөтөлбөрийн хүрээнд лизингийн гэрээгээр авсан цахим ангийн хэрэглэгдэхүүний үлдэгдэл төлбөрөөс шалтгаалсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,047,277.7 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 209,859.5 мянган төгрөг нийт 1,257,137.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлснээс улсын төсвийн санхүүжилтийг 577,699.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1,624,977.6 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвийн санхүүжилтийг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 219,859.5 мянган төгрөгөөр, нийт 1,844,837.1 мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант 2024 онд 9 удаа төсвийн зохицуулалт хийгдэж, улсын төсвөөс 1,507,165.3 мянган төгрөгийн, орон нутгийн төсвөөс 219,859.5 мянган төгрөгийн санхүүжилт, туслах үйл ажиллагааны орлогоос 3,376.3 мянган төгрөгийн, урьд оны үлдэгдлээс 114,436.0 мянган төгрөг зарцуулахаар зэрэг төсвийг нийт **1,844,837.1** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна. Үүнд:

- Тогтмол зардлыг 1,948.0 мянган төгрөгөөр бууруулж,
- Цалин, НДШ-ийн зардлыг 511,824.6 мянган төгрөгөөр,
- Хоолны зардлыг 4,931.9 мянган төгрөгөөр,
- Урсгал зардлыг 11,948.0 мянган төгрөгөөр,
- Мэдээлэл технологийн үйлчилгээний зардлыг 9,918.7 мянган төгрөгөөр,
- Бараа үйлчилгээний бусад зардлыг 47,751.9 мянган төгрөгөөр,
- Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшууллын зардлыг 3,272.8 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 16 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,624,977.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 219,859.5 мянган төгрөг, нийт 1,844,837.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,682,633.9 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,682,633.9 мянган төгрөг буюу 91.2 хувьтай байгаа нь дотуур байрны зардлыг 55,858.8 мянган төгрөгөөр, бичиг үсгийн боловсролын хөтөлбөрийн зардлыг 9,196.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 17,740.7 мянган төгрөгөөр, боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлыг 72,044.9 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс голлон шалтгаалж байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Хөтөлбөр, арга хэмжээ	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт /хувиар/
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>	<b>1,624,977.6</b>	<b>1,480,515.1</b>	<b>146,047.5</b>	<b>91.1</b>
80226 - Байр ашиглалтын үйлчилгээ	2,647.2	2,647.2	-	100.0
80233 - Хүүхэд хамгаалал	2,784.4	2,784.4	-	100.0
80312 - Сургалт семинар	1,903.9	1,647.4	256.5	86.5
81603 - Үндсэн мэргэжлийн тусламж үйлчилгээ	4,000.0	4,000.0		100.0
81605 - Эрүүл мэндийг дэмжих	3,301.3	-	3,301.3	-
81801 - Үдийн цай хөтөлбөр	41,966.6	41,641.9	324.7	99.2
81806 - Дотуур байр	225,611.1	169,752.3	55,858.8	75.2

81816 - Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	42,738.2	42,716.3	21.9	99.9
81823 - Боловсролын байгууллагын багш, ажиллагсадын мэргэжил дээшлүүлэх	7,941.4	7,906.9	34.5	99.6
81827 - Бичиг үсгийн боловсролын хөтөлбөр	9,330.2	134.1	9,196.1	1.4
81834 - Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх	1,259,451.3	1,187,406.4	72,044.9	94.3
81835 - Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	17,304.7	14,340.5	2,964.2	82.9
81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	280.0	140.0	140.0	50.0
81848-Сурах бичгийн түрээс	3,536.3	3,536.3	-	100.0
81875- Сургуулийн нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх	3,696.0	1,861.4	1,834.6	50.4
83603- Дээд шатны төсвөөс	70.0	-	70.0	-
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>219,859.5</b>	<b>202,118.8</b>	<b>17,740.7</b>	<b>91.9</b>
80111 - Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	219,859.5	202,118.8	17,740.7	91.9
<b>ДҮН</b>	<b>1,844,837.1</b>	<b>1,682,633.9</b>	<b>163,788.2</b>	<b>91.2</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хаасан байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Түшиг сумын Ерөнхий боловсролын сургууль хүнсний худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Үдийн цайны материал	38,693.7	38,693.7	ХТШ
2	Дотуур байрны хүнс	42,908.0	42,908.0	ХТШ
	<b>Нийт дүн</b>	<b>81,540.7</b>	<b>81,540.7</b>	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах харьцуулалтын аргаар тендер шалгаруулалт /Анхны батлагдсан төсвөөр тендерийн үнийн саналыг өгсөн/ -ыг үдийн цай, дотуур байрны хүнс гэж 2 тусад нь зарласан байна. Үдийн цайны материалын тендер шалгаруулалтад "Зэлтэрийн өгөөж" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран

2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна. Дотуур байрны хүнсний тендер шалгаруулалтыг дараах 2 багц болгон зарласан байна. Үүнд:

1-Мах, махан бүтээгдэхүүн 21,000.0

2-Бусад хүнс Түшиг шүтээн 21,908.0

Уг шалгаруулалтад "Зэлтэрийн өгөөж" ХХК, "Түшиг шүтээн" ХХК оролцож, гүйцэтгэгчээр шалгаран 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр гэрээ байгуулан, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

---

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Мэдээлэл аудит" ХХК-ийн шинжээч З.Азжаргал гүйцэтгэж, чанарын хяналтыг салбарын захирал А.Гэрэлмаа, анхан шатны хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, хоёр дахь шатны хяналтыг дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Түшиг сумын ерөнхий боловсролын сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Мэдээлэл аудит ХХК-д 2025 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн шатны материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,262,308.7 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 18,934.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Түшиг сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Бичгийн цаас, принтерийн хорны зардлыг хэмнэх зорилгоор бичиг хэрэг, албан хэрэг хөтлөлтөд дотоод сүлжээг ашигласан,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан *“Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”*-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих 29 төрлийн 171 мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй.

### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

#### **4.5.1 Завсрын аудитын талаар**

“Мэдээлэл аудит” ХХК-ийн 2024 оны 11 дүгээр сарын 19-ний өдрийн 24/61 дүгээр *“Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай”* албан бичгийг хүргүүлсэн бөгөөд завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,471.6 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,609.3 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 4,862.3 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн 1 зөрчилд албан шаардлага өгөгдсөн байна.

Өмнөх оны аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг нотлох баримттай тулган баталгаажуулахад өр төлбөр үүсгэсэн зөрчил давтагдан 50.0 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт  
/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,609.3	1	1,609.3	100.0
Албан шаардлага	1	4,862.3	-	-	-
Зөвлөмж	-	-	-	-	-
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>6,471.6</b>	<b>1</b>	<b>1,609.3</b>	<b>50.0</b>

Өмнөх аудитаар төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас өр төлбөр үүсгэсэн зөрчилд өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх “Энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, ... бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтыг үндэслэн нягтлан бодогч Ж.Төгсчимэгт сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой нийт 373,784.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад **271,763.8** мянган төгрөгийн алдааг залруулан, **102,020.5** мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.Үүнд:

#### Залруулсан алдаа:

- Тайлант онд аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс хийгдсэн 110,471.7 мянган төгрөгийн сургуулийн А блокийн дээврийн засварын ажлыг капиталжуулан бүртгэхдээ тусдаа 1 хөрөнгө үүсгэн /2 барилгатай мэтээр/ бүртгэсэн, ашиглах хугацааг зөрүүтэй тогтоосон,
- Тайлант онд нэмэгдсэн 97,544.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийн ашиглах хугацааг буруу тогтоосон,
- Персон хөтөлбөрийн хүрээнд 48 сарын хугацаатай лизингээр Мэксим консалтинг ХХК-с нийлүүлсэн цахим ангийн хэрэглэгдэхүүн нь санхүүгийн

байдлын тайланд өр төлбөрийн болон үндсэн хөрөнгийн дүн 63,747.8 мянган төгрөгөөр дутуу илэрхийлэгдсэн,

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

#### **Залруулагдаагүй алдаа:**

- 18,663.8 мянган төгрөгийн дулааны шугам сүлжээг бусад хөрөнгөөр,
- 83,356.7 мянган төгрөгийн барилгын их засварын гүйцэтгэлийг дуусаагүй барилга дансанд бүртгэсэн байна.

Шийдвэрлэлт: 2025 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд залруулга хийх зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 8,072.9 мянган төгрөгийн 3 зөрчил<sup>1</sup> илэрч албан шаардлага хүргүүлээ.

#### **5.1 Албан шаардлага**

1. Төрөлжсөн хичээлийн олимпиадын 2-ын даваанд болон монгол бичгийн улсын олимпиадын 3-ын даваанд тус тус тэргүүн байр эзэлсэн гэх үндэслэлээр багш Л.Атарцэцэгийг шагнах шийдвэр гаргаж, цалингийн батлагдсан төсвөөс шагналын зардалд 2,730.0 мянган төгрөгийг зардлын бүлэг хооронд гүйлгэн, зориулалт бусаар зарцуулж, гүйцэтгэлийг бодитоор тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно*” гэсэн заалтуудыг болон Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “*Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар*”-ыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, санхүүгийн тайланг анхан шатны баримтад үндэслэн үнэн зөв илэрхийлж байх албан шаардлага хүргүүлэх,

2. Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас цалингийн 544.6 мянган төгрөгийн, хүнсний материалын 521.4 мянган төгрөгийн, нийт 1,066.0 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйл 42.1 дэх “*...хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй*

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

..... нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно” гэсэн заалтын дагуу нягтлан бодогч Ж.Төгсчимэгт **сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.Зайлшгүй шаардлагаар буюу мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас сургалтын менежерүүдэд долоо хоногт заах тогтоосон хэмжээг хэтрүүлэн хичээл заасан гэх үндэслэлээр 4,276.9 мянган төгрөгийн нэмэгдэл цалин хөлс олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашиг, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, БШУЯ-ны сайдын 2023 оны А/386 тоот тушаал 1.1 “Мэргэжлийн багш хүрэлцээгүйн улмаас хичээл, сургалтын тасралтгүй байдал алдагдахад хүрсэн тохиолдолд тухайн сургалтын байгууллагын захирал, сургалтын менежер болон бусад багш мэргэжилтэй ажилтнаар мэргэжлийн дагуу долоо хоногт 6 хүртэл цагийн хичээл заах нөхцөлийг бүрдүүлж, сургалтын хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх арга хэмжээ авах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн ангилал зөрүүтэй	3	212,492.2			3	212,492.2	1	110,471.7	2	102,020.5	2	102,020.5
Ашиглах хугацааг буруу тогтоосон	1	97,544.3			1	97,544.3	1	97,544.3				
Өр төлбөр үүсгэн бүртгээгүй	1	63,747.8	1	63,747.8			1	63,747.8				
<b>Дүн</b>	<b>5</b>	<b>373,784.3</b>	<b>1</b>	<b>63,747.8</b>	<b>4</b>	<b>310,036.5</b>	<b>3</b>	<b>271,763.8</b>	<b>2</b>	<b>102,020.5</b>	<b>2</b>	<b>102,020.5</b>

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингаас шагнал олгосон	1	2,730.0			1	2,730.0						

Өр төлбөр үүсгэсэн	1	1,066.0							1	1,066.0		
Сургалтын менежерийн хичээл заах цагийг хэтрүүлсэн	1	4,276.9			1	4,276.9						
<b>Дүн</b>	<b>3</b>	<b>8,072.9</b>			<b>2</b>	<b>7,006.9</b>		<b>-</b>	<b>1</b>	<b>1,066.0</b>		

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
Бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>								